

## ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 523

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол улсын “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Ёс зүйн салбар хорооны 2014 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “ЭХЭМҮТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтаны биеэ авч явах соёл, ёс зүйн даган мөрдөх журам”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. “ЭХЭМҮТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтаны биеэ авч явах соёл, ёс зүйн даган мөрдөх журам”-ыг нийт ажилтан, албан хаагч наарт сурталчилах, сургалт зохион байгуулах, шинээр ажилд орж байгаа ажилтанд танилцуулан ажиллахыг Ёс зүйн салбар хорооны дарга /О.Амаржаргал/-д үүрэг болгосугай.

Гурав. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ажил үүргээ гүйцэтгэх явцад үйлчлүүлэгчтэй болон өөр хоорондын өдөр тутмын харилцаандбайгууллагын соёл, ёс зүйг эрхэмлэн “ЭХЭМҮТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтаны биеэ авч явах соёл, ёс зүйн даган мөрдөх журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг нийт ажилтан, албан хаагч наарт үүрэг болгосугай.

Дөрөв. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга /П.Отгонгэрэл/-д даалгасугай.

Тав. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2009 оны Ёс зүйн салбар хорооны хурлын шийдвэрээр баталсан “ЭНЭШТ-ийн эмнэлгийн мэргэжилтний биеэ авч явах соёл, хувцаслалт, ёс зүйн даган мөрдөх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.



ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Ш.ЭНХТӨР

Ерөнхий захирлын ..... оны .....-р сарын .....-ны өдрийн  
..... тоот тушаалын ..... хавсралт

**Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтаны биеэ авч явах соёл,  
ёс зүйн даган мөрдөх журам**

### Нийтлэг үндэслэл:

- Эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагааг мөрдөгдөж байгаа хууль дүрэм, тогтоол, шийдвэр, стандарт, тушаалын хүрээнд явуулахад туслах, чиглүүлэх зорилготой.
- Төвийн ажиллагсад ажил үүргээ гүйцэтгэх явцад төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн тангарagt үнэнч байж, үйлчлүүлэгчтэй болон өөр хоорондын өдөр тутмын харилцаанд энэхүү ёс зүйн журмыг мөрдөнө.
- Журамд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг ёс зүйн салбар хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

### Нэг. Ажлын байранд хувь хүний биеэ авч явах хэм хэмжээ

- 1.1. Мэндлэх – бид өдөр тутмын үйл ажиллагаагаа үйлчлүүлэгчтэй болон өөр хоорондоо мэндлэн харьцаагаа эхлэнэ. Ажлын байранд эмч сувилагч, ажилчдыг бүтэн нэрээр эсвэл албан тушаалаар нь нэрлэн харьцах ба найзархах, авгайлан дуудах, үл хүндэтгэсэн байдал гаргахгүй байх.
- 1.2. Үйлчлүүлэгчийн дэргэд, өрөөнд нь хоол идэх, цай уух, хувийн асуудлаа хуваалцахгүй байх.
- 1.3. Ажлын байранд хуруугаар чичиж ярих, уурлах, үйлчлүүлэгчтэй хэрэлдэх, маргалдах, дээрэнгүй хандах, ялгavarлах, аливаа зүйлийг тайлбарлахаас татгалзах, цааргалах зэрэг зохисгүй үйлдэл гаргахгүй байх.
- 1.4. Буруу ташаа, эргэлзээтэй мэдээлэл өгөхөөс татгалзах, зөвхөн үнэн зөв бодит мэдээллийг өөрийн ажил үүргийн хэм хэмжээнд өгөх.
- 1.5. Шаардлага хангаагүй ажлын хувцас, энгэрийн тэмдэггүй, өвчтөн үйлчлүүлэгчдэд тусlamж үйлчилгээ үзүүлэхгүй байх.
- 1.6. Ажлын байранд дүрэмт хувцастай толгой хаялан явах, хөлөө чирж алхахгүй байх.
- 1.7. Үйлчлүүлэгчтэй харьцаж байхдаа бохь зажлах, чихэр хүлхэх, бусадтай ярилцах, утсаар ярих зэрэг үйлчлүүлэгчийг үл хүндэтгэсэн байдал гаргахгүй байх.
- 1.8. Тусlamж үйлчилгээ үзүүлж байх үед, мөн хурал, семинар, хичээл, ярианд оролцож байхдаа гар утасаа унтрааж байх.
- 1.9. Эмнэлгийн болон ажлын дүрэмт хувцастай гадуур явах, үйлчилгээний газар орохгүй байх.
- 1.10. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь мэргэжил нэгт нөхөд, бусад мэргэжилтний эрхийг хүндэтгэн, нөхөрсөг шударгаар харилцан, мэргэжлийн ур чадвар, харилцааны доголдол гаргах, хууран мэхлэх, залилахтай эвлэрэхгүй байхын зэрэгцээ эдгээр үйлдлээс өөрийгөө болон мэргэжил нэгтнээ сэргийлэн ажиллана.

- 1.11. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нар нь ажлын байрандаа цэвэр орчинг бүрдүүлж, хог цаас хаях, тамхи татах, тамхины үлдэгдэл үнсийг орхих, бохь зажилж сандал, ширээн дээр наах, шал, шатан дээр хаяхыг хориглоно.
- 1.12. Ажилтан, албан хаагч нар нь үйлчлүүлэгчийн аюулгүй, амгалан тайван байдалд хяналт тавьж, эд зүйлсээ хараа хяналтгүй газар орхих, хулгайд алдах зэргээс урьдчилан сэргийлэх талаар үйлчлүүлэгчид зөвлөгөө өгнө.

### **Хоёр. Хувцаслалт ба гадаад төрх түүнд тавигдах шаардлага**

#### **2.1. Ажлын дүрэмт хувцсанд тавигдах шаардлага**

- 2.1.1. Эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, ажилтан нь дүрэмт хувцастай байх бөгөөд энэ нь эрхэлж буй ажлын онцлогийг танигдуулахуйц, ажил хэрэгч, цэвэрхэн, толбогүй, үрчийж, нуглараагүй, биед тохиромжтой, хөдөлгөөн хязгаарлаагүй, өнгө үзэмжтэй, өнгөлөг сайхан харагдуулахуйц байна. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан дүрэмт хувцасыг бүрэн өмсөж, товчийг бүрэн товчилсон байна.
- 2.1.2. Ажлын байранд өмсөх гутал нь намхан өсгийтэй, зөөлөн ултай, урдуураа битүү, цагаан буюу цайвар өнгөтэй байна. Өндөр өсгийтэй гутал, сандаал, пүүз, гоёлын болон загварын гутал өмсөхгүй байна.
- 2.1.3. Эрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний оймс цайвар өнгөтэй, хөлний шагайнаас дээш 5 см урттай, эмэгтэй нь биеийн өнгөтэй трико, оймс нь хөлний шагайнаас дээш 4 см урттай, цайвар өнгөтэй байна.
- 2.1.4. Эмэгтэй даашинз, цамц – даашинз, юбка нь өвдөгнөөс доош 2 хуруу урт, цамц-энгэр нь ил гарцаагүй, баруу биш, нэвт гэрэлтэхгүй байх, ухлаадас нь эгэмнээс доошгүй, урт нь хүйснээс доош байна. Эрэгтэй цамц - хэт их хээ, бичигтэй, зурагтай цамц өмсөхөөс татгалзах.
- 2.1.5. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь энгэрийн тэмдэгтэй байх бөгөөд дүрэмт хувцасны энгэрт зүүсэн байна.
- 2.1.6. Гоёл нь аюулгүй байх нөхцөлийг хангасан энгийн жижиг ээмэг, зүүлт байж болно. Хүний анхаарал татахуйц хэт том, урт ээмэг, зүүлт, гинж, бөгж, бугуйвч зэргийг хориглоно.
- 2.1.7. Загварын, баруу, хүйс ил гарсан, шагайнаас дээгүүр татсан, доогуур суудалтай өмд, жинсэн өмд өмсөхгүй байна.
- 2.1.8. Төвийн харуулууд хар хөх өнгийн костюм, цагаан цамц, зангиатай байх бөгөөд энгэрийн тэмдэг заавал зүүсэн байна.
- 2.1.9. Лавлагaa үйлчилгээний ажилтан нь хөх өнгийн пиджак, юбка эсвэл өмд, цагаан цамц, алчууртай байх бөгөөд энгэрийн тэмдэг заавал зүүсэн байна.

#### **2.2. Гадаад төрх байдал, түүнд тавигдах шаардлага**

- 2.2.1. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь үсээ ажил хэрэгч байдлаар зассан байна. Урт үстэй бол мөрнөөс доош үсийг сул тавихгүй ардаа шууж, бооно, урдуураа тайрсан үстэй бол хөмсөгний дээгүүр байх, нүүр нүд рүү сул үс унжуулахгүй байх, үсийг өвөрмөгц тод өнгөөр будаагүй, этгээд засалтгүй байх, эмчилгээний тасгийн сувилагч нар малгайг өмсөнө.

- 2.2.2. Хумсны засалт нь богино, цэвэрхэн байх ба хэрэв будахаар бол өнгөгүй, биеийн өнгө дагуу энгийн даруухан тод биш өнгөөр будна. Хумс завсар бохирдолгүй, хиймэл хумс хэрэглэхгүй, хумс дээрээ гоёлын чимэглэл наахгүй байна.
- 2.2.3. Тод үнэртэн хэрэглэхгүй, биеийн ил хэсэгт гоёлын чимэг зүүлтгүй байх. Сахалгүй байх, сахалтай бол дээд уруул даваагүй байна.
- 2.2.4. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь ажлын байранд нүд, уруул, хацрыг тод, олон өнгөөр будахгүй байх, хиймэл сормуус гэх мэт анхаарал татах содон чимэглэл, будалт хэрэглэхгүй байна.

### **Гурав. Тусlamж үйлчилгээ үзүүлэхдээ баримтлах хэм хэмжээ**

#### **3.1. Биеийн хэлний хэм хэмжээ**

- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчидтэй харилцах үедээ нүүр, царайны төрхөө эерэг сэтгэгдэл төрүүлэхүйц байлгана.
- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь дүрэмт хувцасыг бүрэн өмсөж, товчийг гүйцэд товчилсон байх ба үйлчлүүлэгчтэй мэндлэх үедээ гарaa халаасанд хийх, ташаа тулсан буюу нуруугаа үүрсэн байдалтай байхыг цээрлэнэ.
- Мэндэлж байхдаа үнэн сэтгэлээсээ элэгсэг дотно, эерэг зөөлнөөр, туслах эрмэлзлэлээр харж, хүндэтгэсэн өнгөөр, чанга биш, нам биш дуугаар мэндчилнэ. Ямар ч үед эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчтэй эхэлж мэндэлнэ “*ta*”, “*ta nar*”, “*ta бүхэн*” гэсэн үг хэллэгийг хэрэглэнэ.
- Ямар нэг зүйлийг үйлчлүүлэгчдэд тайлбарлах, чиглүүлэх, хэлэх тохиолдолд хуруугаар заах, дохих, зангах, гарын хөдөлгөөн нь биеийн байрлал, нүүр царай, харцнаас өөр чигт байх, төвөгшөөн, ундууцаж, уцаарласан төрхийг хориглоно. Гарын хөдөлгөөн зөөлөн, урьсан байдалтай, биеийн байрлал, нүүр царай, харц нь гарын чиглэлийг дэмжсэн өнгө аястай байхаар намдуу зөөлөн дуугаар тайлбарлаж, чиглүүлнэ.
- Тусlamж үйлчилгээг үзүүлж байхдаа сандарч тэвдэх, хөшүүн хойрго байх, чанга хашгирах, инээх, ярихыг цээрлэж, тайван, зөөлөн, урам зоригтой, итгэлтэй байхаар алхаа гишгээгээ тохируулна.
- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь өөдрөг сэтгэлгээтэй, өөртөө итгэлтэй байж, хамт олон, үйлчлүүлэгчдэд итгэл үнэмшил, баяр баясгаланг өгөхийн төлөө тасралтгүй суралцаж чармайн ажиллана.

#### **3.2. Харилцааны хэм хэмжээ**

- Эрүүл мэндийн ажилтан хэн боловч үйлчлүүлэгчтэй мэндлэхдээ бүтэн өгүүлбэрээр мэндчилнэ. Тухайлбал: “Сайн байна уу? Танд юугаар туслах вэ?”, “Та сайн байна уу?, Танд юугаар туслах вэ?”, “Манайхаар үйлчлүүлэхээр ирсэн танд баярлалаа, юугаар туслах вэ?”, үзлэгийн өрөөнд байгаа үйлчлүүлэгчийн хувьд “Сайн байна уу Дорж гуай?” гэх мэт.
- Тусlamж үйлчилгээ үзүүлэх гэж буй хүн эхэлж өөрийгөө танилцуулна. Тухайлбал: “Би сувилагч, Дулмаа байна” гэх мэт үйлчлүүлэгчийн асуусан асуултанд тохирсон хариултыг өгнө.

- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь эмнэлгийн тусlamж үзүүлэх, ярилцах үедээ үйлчлүүлэгчтэй хүрэлцэхүйц хэм хэмжээнд, нүүр нүүрээ харан, гол төлөв баруун талыг нь барин сууна.
- Үйлчлүүлэгчийн тав тух хангагдсан эсэхийг тодруулна. Тухайлбал: “Таны байрлал тавтай байна уу?”, “Суудал танд тохиromжтой байна уу?”, “Ингэж суух нь танд эвтэйхэн байна уу?”, “Танд эвтэйхэн байна уу?” гэх мэт.
- Үйлчлүүлэгчтэй ярилцаж байхдаа нүд рүү нь харж, анхааралтай ажиглан үйлчлүүлэгчийг ойлгож, анхаарч байгаагаа хэл яриа, биеийн хөдлөлөөр илэрхийлэх, түүнд таагүй сэтгэл төрүүлэхээс болгоомжлох, аль болохоор нээлттэй энгийн асуултыг тавьж, ярилцлагыг илүү чөлөөтэй болгоно.
- Үйлчлүүлэгчийн карт, өвчний явцтай танилцсан тухайгаа илэрхийлнэ. Тухайлбал: “Танд нэмж хэлэх, тайлбарлах зүйл байна уу?”, “Та тодруулж хэлэх зүйл байна уу?”, “Та надад тодруулаад өгөөч” гэх мэт.
- Үйлчлүүлэгчийн ярьж байгаа зүйлд анхаарлаа хандуулан, өөрийгөө анхааралтай сонсож байгааг илэрхийлэхийн тулд “толгой дохих”, “харцаараа харилцаа тогтоох”, “тиймээ”, “яг үнэн”, “аанха”, “та зөв ярьж байна”, “маш сайн байна”, “та өөрийнхөө өвчний талаар сайн мэдэрч байна” гэх мэт үйлчлүүлэгчийн яриаг дэмжин, урам өгсөн үг, хэллэгийг хэлж байх.
- Үйлчлүүлэгчийн яриаг таслахгүй байхыг хичээж, юуны тухай ярих, юунд анхаарлаа хандуулахыг урьдчилан тайлбарлаж, ярьсан зүйлээс шаардлагатай зүйлийг нь эргүүлэн асууж, тодруулан тэмдэглэн авах.
- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь албаны утсаар хувийн чанартай зүйлийг ярихгүй байхаас гадна үйлчлүүлэгчдэд тусlamж үйлчилгээ үзүүлж байгаа үедээ гар утас хэрэглэхийг хориглоно.
- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нар хамт олон, мэргэжил нэгт нөхдийнхөө нэр хүндийг унагах, үг, яриа, хэллэг, үзэл бодол, үйл хөдлөлөөрөө илэрхийлэхийг хориглоно.
- Үйлчлүүлэгчдэд таагүй мэдээ хүргэхдээ заавал тусгайлсан /уулзалтын/ өрөөнд хөндлөнгийн хүн байхгүй тохиолдолд тухайн үйлчлүүлэгчтэй хэрхэн харилцаахаа төлөвлөн, хэрхэн яаж, юнаас эхлэхээ эмнэлгийн мэргэжилтэн өөрөө шийдвэрлэнэ. “Таны шинжилгээний хариу муу гарсан байна”, “Танай хүн нас барсан”, “Танай хүн найдваргүй боллоо” гэх мэт тааруу мэдээг гэнэт, шууд хэлэхийг хориглоно.
- Эмнэлгийн мэргэжилтэн харилцаандаа дараах чухал үгийг байнга хэрэглэж хэвшүүлнэ.
  - “Уучлаарай”, “Миний буруу, намайг уучлаарай” “Би алдаа хийжээ, уучлаарай”
  - “Та ажлаа маш сайн хийлээ”
  - “Таны санал юу вэ”
  - “Хэрэв та хүсвэл”
  - “Танд баярлалаа”
  - “Би”

### 3.3. Утсан харилцааны хэм хэмжээ

- Эхний дуудлагаар хийж байсан ажлаа түр орхих бэлтгэл хийнэ.

- 2 -3 дах дуудлагаар утсыг авна.
- Мэндлэнэ.
- Тасгийн нэр, албан тушаал, нэрээ хэлнэ. Жны: АЭЭСТ-ийн сувилагч Саран сонсож байна.
- Харилцагчийн яриаг бүрэн гүйцэд сонсоно.
- Харилцагчид үнэн зөв, бүрэн хариултыг өгнө.
- Хэрвээ та эмнэлэг үйлчилгээний ажлаар завгүй эсвэл харилцагчийн асуултанд хариулах боломжгүй байгаа бол учлал гүйж\_ учир шалтгаанаа тайлбарлана.
- Утсаар ярихдаа анхаарах зүйл:
  - Сэтгэлийн хөдөлгөөнөө барих.
  - Мэдэхгүй, чадахгүй, үгүй, гэдэг үгийг хэлэхгүй байх.
  - Хэрэв хэлэх тохиолдол гарвал учлал гүйх.
  - Утсаар ярьж дууссаны дараа баяртай гэж заавал хэлнэ

### 3.4. ЭХЭМҮТ-ийн цээрлэх зүйл

- Хүнд суртал, үйлчилгээний чирэгдэлтэй байдал
- Үйлчлүүлээд гарсны дараах үйлчилгээ, эргэх холбоогүй ажиллах байдал
- Хүлээлгийн танхимд хэний ч анхаарал тусlamж авдаггүй байдал
- Үйлчлүүлэгчийн буруу байсан ч тэдэнтэй маргалдах үл ойлголцох
- Үйлчилгээний ил тод, нээлттэй байдал тодорхой биш байх
- Үйлчилгээний хатуу горим, уян хатан биш байдал
- Эмнэлэгт хэвтэхийн өмнөх үеийн тусlamж үйлчилгээ, санамж зөвлөлгөө хангалтгүй байх

### 3.5. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны цээрлэх зүйл

- Ихэмсэг, их зан
- Шудрага бус байдал
- Хувийн зохион байгуулалтгүй, бүдүүлэг байдал
- Хуурамч байх, хуурамч дүр үзүүлэх
- Тэвчээргүй байдал
- Хайнга, хариуцлагагүй байдал
- Бусдыг үл хүндэтгэсэн байдал
- Хэт нэг талыг барих буюу буруу зүйлийн төлөө тэмцэх
- Хувийн эрх ашгийг байгууллага, хамт олны эрх ашгаас өмнө тавих зохисгүй байдал

**Дөрөв. Ёс зүйн даган мөрдөх хэм хэмжээ**

### 4.1. Тусlamж үйлчилгээг чанартай үзүүлэхэд мөрдөх хэм хэмжээ:

- 4.1.1. Үйлчлүүлэгчдэд төрөлжсөн мэргэжлийн тусlamж үйлчилгээг хүртээмжтэй, чанартай, аюулгүй, оношилгоо эмчилгээний удирдамж, стандартыг мөрдөн, мэдлэг, ур чадварыг дайчлан ажиллана. Үйлчлүүлэгчийн доорхи эрхийг хүндэтгэн, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэн ажиллана.

- Мэдээлэл авах
- Хүссэн үйлчилгээндээ хамрагдах
- Сонголт хийх боломжоор хангагдах
- Аюулгүй үйлчилгээ авах
- Хувийн нууцыг хамгаалулах
- Хүндэтгэл, тав тухтай орчинд үйлчлүүлэх, санаа бодлоо илэрхийлэх

**4.2. Яаралтай тусlamж үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх хэм хэмжээ:**

- 4.2.1. Эх, хүүхдэд яаралтай тусlamж үйлчилгээг Эрүүл мэндийн тухай хууль, холбогдох бусад дүрэм, журам, тушаалыг мөрдөн цаг алдалгүй үзүүлнэ.
- 4.2.2. Яаралтай тусlamж шаардлагатай үйлчлүүлэгчийг товлол харгалзахгүйгээр тусlamж үйлчилгээ үзүүлж, дараагийн шатны арга хэмжээг авна.

**4.3. Хувь хуний нууцыг хадгалах :**

- 4.3.1. Эрүүл мэнд, гэр бүлийн байдал, удам судар, удмын өвчлөлийн талаар цуглуулсан мэдээллийг эмчлэгч эмч сувилагч, тухайн үйлчлүүлэгчдэд нэмэлт тусlamж үйлчилгээ үзүүлсэн эмнэлгийн мэргэжилтэн нар бусдад задлах хэлэлцэн ярилцах, дамжуулах зэрэг үйлдэл гаргаж үл болно.

**4.4. Санхүүгийн үйл ажиллагааны мэдээлэл:**

- 4.4.1. Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн биелэлт, хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх.
- 4.4.2. Зөвхөн хууль тогтоомжинд заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлэх.

**4.5. Мэдээллийн аюулгүй байдал ба нууц байдал:**

- 4.5.1. Эмнэлгийн ажилтнууд өөрийн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг тухайн ажил үүргээ биелүүлэх явцад хэрэглэж болох ба зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд өөр этгээдэд дамжуулахыг хориглоно.
- 4.5.2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс интернетээр явуулах бичиг баримтыг тусгайлан кодлосон байна.
- 4.5.3. Эмнэлгийн дотоод сүлжээнд эмнэлгийн болон бизнесийн өргөн хүрээний мэдээлэл хадгалагддаг тул ажилтан бүр дотоод сүлжээ, түүнд хадгалагдаж байгаа мэдээллийг хамгаалах үүрэгтэй бөгөөд нууц үгийг бусдад дамжуулахыг хориглоно.

**4.6. Өмч хөрөнгийг хамгаалах:**

- 4.6.1. Эмнэлгийн эд хөрөнгө, өрөө тасалгаа, тоног төхөөрөмжийг ариг гамтай ашиглаж, эвдрэл гэмтлээс хамгаалах.
- 4.6.2. Ажилтан, албан хаагч нар бага зардлаар үр дүнтэй ажиллах, зардлаа хэмнэх, бууруулахад анхааран ажиллах.

4.6.3. Ажлын цагийг өөр зүйлд зарцуулах, эмнэлгийн материал, эд хөрөнгийг эмнэлгийн бус зорилгоор хэрэглэх, зөвшөөрөлгүй эмнэлгээс гадагш гаргахыг хориглоно.

4.7. Харилцаа холбоо:

4.7.1. Харилцаа холбоо тухайлбал: емайл, интернет, утас, дуут шуудан зэрэг нь эмнэлгийн өмч тул зөвхөн ажлын хэрэгцээнд ашиглана.

4.7.2. Эмнэлгийн холбоог хувийн зорилгоор ашиглах, эвдрэл гэмтэл учруулахад сахилгын хариуцлага ноогдуулна.

4.8. Бэлэг урамшуулал:

4.8.1. Эмнэлгийн ажилтнууд өөрсдийн шийдвэр гаргах, мэргэжлийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх ямар нэг бэлэг, үйлчилгээ, бусад үнэт зүйл авах, соёлын арга хэмжээнд оролцохыг хориглоно.

4.8.2. Эмнэлэгтэй хамтран ажиллаж буй бизнесийн байгууллага үйлчилгээндээ ямар нэг хөнгөлөлтийг санал болгож болно. Ийм саналыг зөвхөн эмнэлгийн удирдлагаар хэлэлцүүлэн хууль бус ёс зүйгүй төлбөр биш болох нь тогтоогдсон байх ёстой.

4.8.3. Үйлчлүүлэгч тэдний гэр бүл зочид болон бусад хүмүүсээс эмнэлэгт хандивлах зорилгогүй санал болгож байгаа бэлэг урамшууллыг авахаас зэлдэгээр татгалзана.

4.8.4. Үйлчлүүлэгчийг эмнэлэгт үзүүлсэн, хэвтүүлсэний төлөө төлбөр, урамшуулал өгөх ба авахыг хориглоно.

4.9. Ашиг сонирхлын зөрчил:

- Эмнэлгийн ажилтнууд байгууллага, хамт олноо гэсэн үнэнч сэтгэлээр ажиллах үүрэгтэй.
- Тэд албан тушаалаа хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахыг хориглоно.
- Ашиг сонирхлын зөрчил гэж хувийн буюу бусдын ашиг сонирхол ажилтны ажил үүргээ гүйцэтгэх, бодит шийдвэр гаргах явцад нөлөөлөх, эсвэл нөлөөлж байгаа мэт харагдахыг хэлнэ.
- Ашиг сонирхлын зөрчилтэй ямар нэг үйл ажиллагаа илэрвэл нэн даруй холбогдох дээд шатны албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй.
- Ажилтнууд ашиг сонирхлын зөрчил үүсэх дараах нөхцөл байдлаас зайлсхийх үүрэгтэй. Үүнд:
  - Тухайн эмнэлэгт ажиллаж байхдаа түүний өрсөлдөгч байгууллагад давхар ажил хийх
  - Эмнэлэгтэй ажил хэргийн холбоо тогтоохыг эрэлхийлж байгаа хүмүүсээс бэлэг, төлбөр, үйлчилгээ авах
  - Эмнэлгийн ажилтан болон гэр бүлийн хүмүүсийн эрхэлж буй бизнесийн байгууллагатай ажил хэргийн холбоо тогтоох
  - Эмнэлгийн өрсөлдөгч байгууллага эсвэл ханган нийлүүлэгч байгууллагад зөвлөхөөр ажиллах

4.10. Ажилд тэнцэхгүй хүн

- Тус төвд урьд нь ажиллаж байгаад шийтгэл хүртэж ажлаас халагдсан, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхээ түдгэлзүүлсэн, гэмт хэргийн үйлдэлд сэжиглэгдсэн буюу холбогдсон, бичиг баримт хуурамчаар бүрдүүлсэн, өмнөх ажлаасаа сахилга хариуцлага, ёс зүйн алдаа гарган халагдсан хувь хүнийг шинээр буюу сул ажлын байранд ажилд авахгүй.

**Гадны байгууллага, хувь хүнд тараахыг хориглоно. Зөвхөн ЭХЭМҮТ-ийн хэмжээнд мөрдөгдөнө.**